



МЭРГЭЖЛИЙН СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН КОМПАНИ

**ХӨТӨЧ  
ТАЙЛБАРЛАГЧИЙН  
ХӨДӨЛМӨРИЙН  
ЗАХ ЗЭЭЛ**

June 29  
**2021**

---

*СУУРЬ СУДАЛГАА*

## АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ	
СУДЛАГДСАН БАЙДАЛ .....	4
ЗОРИЛГО ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....	5
АРГА ЗҮЙ.....	
СУДАЛГААНЫ ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ .....	6
НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВЭР, БҮТЭЦ .....	7
1.1 Хөтөч тайлбарлагчид .....	
1.2 Ажил олгогчид.....	
1.3 Сургалтын байгууллага .....	
ХОЁР. ХӨТӨЧ-ТАЙЛБАРЛАГЧИЙГ БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦ .....	12
2.1 Мэргэжил эзэмшсэн байдал	
2.2 Сургалтын байгууллагын үнэлгээ	
2.3 Сургалтын хэрэгцээ шаардлага	
2.4 Сургалтын үйл ажиллагаа, асуудлууд	
ГУРАВ. ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ .....	22
3.1 Цалин, урамшуулал	
3.2 НДШ ба бусад даатгал	
3.3 Ажлын хэрэгцээ хангамж	
3.4 Эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь	
3.4.1 Ажлын байрны тодорхойлолт	
3.4.2 Хөдөлмөрийн гэрээний анализ	
3.4.3 Зэрэглэл ангилал тогтоох, эрхийн үнэмлэх, индекс	
3.5 Ковид ба цар тахлын үеийн аяллын хөтөч тайлбарлагчдын нөхцөл байдал, хүний нөөцийн шилжилт	
3.6 ТУЛГАМДСАН АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ	
СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	39
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	41

## УДИРТГАЛ

### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Аялал жуулчлалын салбарын хөгжлийн хамгийн гол хүчин зүйлүүдийн нэг бол хүний нөөц тэр дундаа ур чадвартай хөтөч-тайлбарлагчид юм. Манай орныг зорин ирсэн жуулчид дахин ирэх эсэх, аяллын талаар бусдад эерэг сэтгэгдлийг төрүүлэх эсэх цаашлаад аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд хөтөч тайлбарлагчийн үүрэг оролцоо чухал юм. Иймд хөтөч тайлбарлагчдийн тогтмол хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, зэрэглэл тогтоож үнэлэх ажлыг хөдөлмөрийн зах зээл дэх хэрэгцээ шаардлага, салбарын нөхцөл байдалд уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатайг өнгөрсөн жилүүдэд манай улсад аялсан жуулчдын сэтгэгдэл, хэвлэлийн мэдээ, судалгааны дүнгүүдээс харж болно.

2019 оны эцсээр ковидийн нөхцөл байдал үүсэхээс өмнөхөн Монгол банк, АЖХТ-ийн хамтран хийсэн судалгаанд оролцогч 10 жуулчин тутмын 1 нь хөтөч тайлбарлагч нь туршлага, мэдлэг чадварын хувьд хүлээлтээс доогуур байсан гэсэн үнэлгээг өгсөн байна. Тус судалгаа авагдсанаас хойшхи жил хагасын хугацаанд аялал жуулчлалын салбар бүхэлдээ тэг зогсолт хийсэн ч хүн амыг цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалт ойрын саруудад бүрэн хийгдэж Монгол улс хилээ нээхээ олон улсад зарласан байгаа билээ.

Зогсолт хийх хугацаанд салбарын хүний нөөцийн хувьд шилжилт үүсч ур чадвартай хөтөч тайлбарлагч нар өөр ажил эрхлэх эрсдэлтэй нөхцөл үүссэн байх магадлалтай учраас хөтөч тайлбарлагчдаас шуурхай судалгаа авч, цар тахалтай тэмцэх шинэ хэвийн дэглэмд шилжиж буй энэ үед жуулчдаа хүлээж авах бэлтгэл ажлыг хангахад хөтөч тайлбарлагчдадаа анхаарах шаардлагатай байна.

Сайн хөтөч тайлбарлагчтай аялал авсан жуулчны сэтгэл ханамж өндөр байдаг. Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээлд тэднийг бэлтгэх, нийлүүлэх, амьдрал ахуйг нь дэмжин дээшлүүлэхэд хууль, гэрээ бусад хөдөлмөрийн харилцааны актуудад тусгагдсан шаардлага, эрх, үүргийн хэрэгжилтийн байдал, ажил олгогчидтой харилцах хөдөлмөрийн харилцаанд тус хуулийн үйлчлэл, дутагдалтай тал, хөтөч тайлбарлагчийг зах зээлд нийлүүлэгчдийн хууль эрх зүйн зохицуулалтын орчин, сургалтын чанар, тулгамдсан асуудлуудыг судлан тодорхойлж, бодлого арга хэмжээнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай юм.

#### **Судалгааны үндэслэл, хэрэгцээг тоймловол:**

I. Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээлд цар тахлын нөлөөллийг илрүүлэх, ирэх оны эрэлт нийлүүлэлтийн төлвийг тодорхойлох

II. Аялал жуулчлалын тухай хуульд тусгагдсан шаардлага, эрх үүргийн хэрэгжилтийн нөхцөл байдал, хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээл дээрх шинэ эрэлт хэрэгцээг хуулинд тусгах шаардлагыг тодруулах

III. Хөдөлмөрийн зах зээл дэх хөтөч тайлбарлагчдийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хөдөлмөрийн гэрээний зохицуулалтын байдал, гэрээнд тусгагдсан ажлын байрны тодорхойлолт, хөтөч тайлбарлагчийн эрх үүрэг, үнэлгээ, цалин хөлс, урамшуулал, ажлын байрны нөхцөл хангамжинд шинжилгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах шийдлийг тодорхойлох

IV. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан мэдлэг, ур чадваруудын түвшинг хөдөлмөрийн харилцаанд оролцогчдоор үнэлүүлж, эрэмбэлүүлэх, сургалтанд хамрагдалт, ёс зүйн дүрмийн хэрэгжилт гэх мэт асуудлуудыг судалж оновчтой шийдэл, саналыг боловсруулах шаардлагатай байна.

## **СУДЛАГДСАН БАЙДАЛ**

Аялал жуулчлалын салбарын судалгаанд хөтөч, тайлбарлагчийг хөгжүүлж сургах үйл ажиллагаа, ажил олгогч ба хөтөч тайлбарлагч хоорондын хөдөлмөрийн харилцаа, хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээл дэх үнэлгээ, эрэлт нийлүүлэлт талаас нь нарийвчилан судалсан судалгаа ховор байна. Их, дээд сургуулиудийн магистр, докторын судалгааны бүтээлүүдээс ХААИС-ийн магистр Д.Насанжаргал “Монголын аялал жуулчлалд Хятад хэлтэй хөтөч тайлбарлагчийн ур чадварыг сайжруулах нь” сэдвээр аялал жуулчлал, бизнесийн удирдлагын магистрын зэрэг горилсон бүтээл, “Газарчин” Их сургуулийн Аялал жуулчлалын эдийн засагч-менежерийн ангийг төгссөн Лхагвасүрэнгийн Лхамсүрэн “Шувуу ажиглах аялалын хөтөч тайлбарлагчийг бэлтгэх нь” сэдвээр бакалаврын зэрэг горилсон бүтээл, ГГС –ийн Нийгмийн газар зүй, аялал жуулчлалын тэнхимийн магистр Ч.Амарсанаагийн “Монголын аялалын хөтөч - тайлбарлагчийн мэргэжлийн ур чадварын судалгаа”, Монголын өрсөлдөх чадварын санаачлагын төвийн хөтөч тайлбарлагчийн үнэлгээний судалгаа, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбооны хийсэн судалгаа зэрэг нь хөтөч тайлбарлагчийн судалгаанд онол арга зүйн дэвшилттэй арга хэлбэрийг ашиглажээ. Эдгээр судалгааны ажлуудаас “Монголын аялалын хөтөч - тайлбарлагчийн мэргэжлийн ур чадварын судалгаа” нь хөтөч тайлбарлагч нарын ур чадварыг нарийвчлан судалж гүйцэтгэлд үнэлгээ хийх шинэлэг аргыг хэрэглэжээ. Цаашид аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа сэргэж хэвийн нөхцөлд шилжсэн үед хөтөч тайлбарлагч нарын ажлын байрны зураг авалт хийх, жуулчдаас санал асуулга авч энэхүү гүйцэтгэлийг үнэлэх аргачлалаар судалгаа явуулах шаардлагатай.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО**

Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа нь ажил олгогчын талаас хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, мэргэжилтэн нийлүүлэгч талаас мэдлэг ур чадвартай хөтөч тайлбарлагч бэлтгэж чадаж байгаа эсэх, горьлогч талаас энэ мэргэжлийн үнэ цэнэ, цалин хөлсний үнэлгээ, хөдөлмөрийн нөхцлийн талаарх тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилготой.

## **ЗОРИЛТ**

1. Хөтөч тайлбарлагчийг бэлтгэдэг сургалтын байгууллагуудын сургалтын хөтөлбөр салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэж буй эсэх;

2. Ажил олгогч талаас мэдлэг ур чадвартай хөтчийг тогтвортой ажиллуулах, ажлын орчин нөхцлийг сайжруулах боломжийг тодорхойлон дэвшүүлэх;
3. Хөтөч тайлбарлагчийн талаас ажлын байран дахь тулгамдсан асуудлуудыг илрүүлэх.

### **Үргэлжлэх хугацаа:**

2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл судалгааны ажлыг гүйцэтгэв.

### **СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, АРГАЗҮЙ**

#### ***Хамрах хүрээ:***

Судалгааны хамрах хүрээ нь аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчид, хөтөч тайлбарлагчид, сургалтын төвүүдүүдийг тус судалгаанд оролцуулсан болно.

#### ***Судалгааны арга зүй:***

Санал асуулгын аргаар онлайн хэлбэрээр мэдээлэл цуглуулж, үр дүнг боловсруулж, хөдөлмөрийн гэрээ, бусад бчиг баримтуудад анализ хийж дүгнэлт зөвлөмж боловсруулан ажиллав.

#### ***Түүвэр:***

Хамрах хүрээ	Тоо	Судалгаанд хамруулах түүвэр
Хөтөч тайлбарлагч	1352	134
Ажил олгогч	1131	16
Сургалтын төвүүд	5	3

Судалгааны түүврийн хувьд хөтөч тайлбарлагчид цөөхөн тул аль болох бүгдийг оролцуулах, тэдэнтэй эргэж холбогдох мэдээллийн сан үүсгэх зорилго тавьсан ч аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа зогсонги хэвээр хөтөч тайлбарлагчид ажилгүй, орлогогүй үе таарсан, нөгөө талаас өмнөх хийгдсэн судалгаануудын үр дүн эргэж мэдээлэгддэггүй, тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэдэггүй зэрэг шалтгаанаар судалгаанд бүрэн дүүрэн хамрагдаагүй болно. Гэсэн хэдий ч судалгаанд төлөөлөх түүвэр хангалттай бүрдэж нийт 134 хөтөч тайлбарлагчид оролцсон байна. Судалгааны багаас тэдний гэр бүл, ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, цалин орлого, зээл зэрэг санхүүгийн асуултуудыг санал асуулгын агуулгад багтаан мэдээлэл цуглуулсан нь

цаашид тэдний хувьд тулгамдсан асуудлыг шийдэх шийдэл, бодлогын хувилбарыг гаргахад ач холбогдолтой мэдээллийн санг бүрдүүлэхэд зорьсон болно.

Ажил олгогч талуудаас 16 ААН, тур операторууд асуулгад оролцож, санал бодлоо илэрхийлсэн байна. Сургалтын байгууллагуудаас хөтөч тайлбарлагчдаас хамгийн өндөр үнэлгээг өгсөн хамгийн туршлагатай төвүүд болох Гайд төв, МХТХолбоо, мөн шинэхэн байгуулагдсан Бондоолой сургалтын төвийн багш, төлөөлөл судалгаанд оролцлоо.

## **СУДАЛГААНЫ ҮНЭЛГЭЭ**

Судалгааны багаас ажлын даалгавар болох хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээл сэдэвт судалгааны ажлын зорилго, зорилтоо боловсруулах явцад судлагдсан байдлын хүрээнд маш олон судалгааны асуулт, тулгамдсан асуудлууд тухайн сэдэвтэй холбоотойгоор судлагдахгүй орхигдсон байсан. Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой тэр олон асуудлуудаас ялангуяа цалин, хөлс, сэтгэл зүй, үнэлгээний талаарх судалгаа огт байдаггүй гэж хэлэхэд болно. Иймээс судалгааны багийн зүгээс анх удаа хөтөч тайлбарлагч нараас цалин, орлого, зээл, гарын мөнгө, урамшуулал авдаг эсэх гэх мэт санхүүгийн хувийн шинж чанартай асуултуудыг санал асуулганд оруулж, цаашид тэдний нийгмийн асуудлыг шийдэхэд бодлого боловсруулагч, ажил олгогч нарт мэдээлэл өгөх зорилт тавин ажиллалаа. Иймээс хэт хувийн асуулт асуусан гэх сэтгэгдэл цөөнгүй ирсэн бөгөөд судалгааг үнэлүүлэх асуултанд хариулсан хариултын дийлэнхи нь дэлгэрэнгүй, хэрэгтэй судалгаа гэж үнэлжээ.

### ***Судалгаанд оролцогчдын хариултнаас...***

*"...Ерөнхийдээ нэлээн дэлгэрэнгүй судалгаа болсон байна. Ажлын байран дахь хөтчийн сэтгэл зүйн талаар анхаарах судалгаа хийвэл бас зүгээр юм. Жишээ нь дөнгөж шинээр ажилд орж байгаа хүмүүсийн сэтгэл зүйн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж даван туулах ба бид өвөл хаврыг алгасан зундаа л ажилладаг учир сэтгэл зүйн хувьд, мэдлэг, чадварын хувьд байнгын апдэйт хийж байх шаардлагатай санагддаг. ЭНэ талаар хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодруулан судалгаандаа анхаарвал зүгээр санагдлаа.*

*Хэрэгтэй судалгаа байна.*

*Боломжийн.Гэхдээ цалин урамшуулал гэх мэт хэт хувийн орон зайруу халдаж байна.*

*Гадаадад ажиллах шаардлага гардаг буюу аутбаунд аялалд явдаг, ахлагч, гайдуудад ажиллах нөхцлийн талаарх асуултууд алга. Бас нэг төрлийн хариуцлагатай мэргэжил бөгөөд ажил байдаг.*


*Хэдийгээр харицангуй шинэ ойлголт ч гэсэн Ажиллах нөхцөл, эрх, үүрэг хариуцлага, зэргийг одооноос тодруулан стандартжуулах шаардлага байгаа гэж хардаг.*

*Хөтөч нар өөрсдөө эрсдэлд орох магадлал өндөр байдаг. Жишээ нь нутгийн хүмүүсээс гутаан доромжлох, хоолны тоонд багтаагүй байх, хулгай зэлгий болоход хөтөч хамгийн түрүүнд байцаалтанд орох гэх мэт гэнэтийн асуудал гардаг талаар судлах хэрэгтэй байх..."*

## **НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВРИЙН БҮТЭЦ БА ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

### **1.1.1 Хөтөч тайлбарлагчийн социаль бүтэц.**

Судалгаанд оролцсон нийт 134 респондентуудыг насны бүлгээр нь авч үзвэл 25.4% нь 26-30 насныхан, 21.6% нь 31-35 насныхан, 17.2% нь 36-40 насныхан, 13.4% нь 41-45 насныхан, 12.7% нь 18-25 насныхан, үлдсэн 9.7% нь 46-аас дээш насныхан тус тус оролцжээ. Идэвхитэй ажлын насныхан буюу 18-45 насныхан нийт оролцогчдын 77.6 хувийг эзэлж байна.




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Хүйсийн харьцааны хувьд 77.6% нь эмэгтэй хөтөч тайлбарлагчид хамрагдсан байна.

### 1.1.2 Ам бүл

Зураг 3. Өрхийн ам бүлийн тооны бүлэглэлт (n=134)




Судалгаанд оролцогчдын 75% нь гэр бүлийн 3-5 гишүүдтэйгээ амьдардаг байна.

### 1.1.3 Хөтөч, тайлбарлагчаар ажилласан жил болон гадаад хэлний мэдлэг:

Аялал жуулчлалын чиглэлээр их, дээд сургууль, чиглэлийн сургалтад хамрагдсан 70.2 хувийн респондетийн 48.5% нь 1-3 жил бөгөөд 1-6 жил ажиллаж байгаа нийт 67.9% байна. 13-аас дээш жил ажиллаж байгаа 16.4% нь байгаагаас харахад тус салбарын жаргал, зовлон, алдаа дутагдал, тулгамдсан асуудлуудыг хамгийн сайн мэдэх респондентууд түүвэрт хамрагджээ.






Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

### 1.1.4 Хөтөч тайлбарлагчийн амьжиргааны байдал:


Судалгаанд хамрагдсан респондентуудын /хөтөч, тайлбарлагч/ хувьд орлогын байдал цар тахлын өмнөх хэвийн үед амьжиргааны зардлаа зохицуулаад бага хэмжээгээр илүү гардаг гэж 38.8%, хангалттай сайн, хуримтлалтай болдог гэж 30.6 хариулсан байв. Эндээс тооцоход 69.4% нь ямар нэг байдлаар амьжиргаагаа хангаад, илүү гарсанг хуримтлуулдаг буюу хангалттай орлоготой байсан нь харагдаж байна. Харин 30.6, нь хангалтгүй орлоготой байсан байна.



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн


### Зээлтэй эсэх:

Судалгаанд ошролцогчдын 67.9% (91) нь банкинд ямар нэгэн зээлтэй гэж хариулсан. Тэдгээрийн 28% (26) нь 5 хүртэлх сая төгрөг, 21.5% нь 5-10 сая төгрөгийн зээлтэй байгаа бол үлдсэн 50.5% нь 10-с дээш сая төгрөгийн зээлтэй байна.



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Зураг 10. Зээлийн төрөл (n=91)



Респондентуудын 67.9% нь зээлтэй байсан бөгөөд 2047.01-р сард төлж дуусах орон

сууцны зээлтэй гэж харцуулснаас үзэхэд тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, нийцсэн бодлого боловсруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Цар тахлын энэ үед хамгийн хямралтай байгаа, огт ажиллаагүй салбар бол аялал жуулчлалын салбар бөгөөд өнөөдрийн байдлаар судалгаанд оролцсон хөтөч, тайлбарлагчдийн хувьд 3-4 ам бүлтэй гэр бүл дийлэнх буюу 57.5 хувийг эзэлсэн байна. Тухайн гэр бүлийн хувьд 41.8% нь орон сууцны зээлтэй бөгөөд энэхүү мэргэжил, улирлын онцлогоос шалтгаалан орлого олох боломжтой үе нь 6-9 дүгээр сар юм. Өнөөдрийн байдлаар хорио цээрийн дэглэмтэй холбоотой тус салбар нь жуулчид хүлээж


авах нөхцөл боломж бүрдээгүй байсан бол энэ жил мөн л нөхцөл байдал давтагдаж тулгамдсан асуудал болоод байна.

Судалгааны социаль бүтэц болох нас, хүйс, боловсролын байдал, амьжиргааны түвшин зэрэг асуултад хариулсан байдлаас харахад 1-6 жил ажиллаж буй аялал жуулчлалын чиглэлээр сургалтад хамрагдсан, англи, солонгос хэлний мэдлэгтэй, 3-5 ам бүлтэй, орон сууцны зээлтэй 26-35 насны эмэгтэйчүүд түүврийн төлөөлөл болж буй дүр зураг, үр дүн харагдаж байна.


## 1.2 Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын төлөөлөл

Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаанд 16 ажил олгогч хамрагдсан байна.

*Зураг 11. Танай компани аялал жуулчлалын салбарт хэд дэх жилдээ үйл ажиллагаа эрхэлж байгаа вэ?*




*Зураг 12. Аль орны зах зээл дээр голчлон ажилладаг вэ?*



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Тус ажил олгогчдын хувьд аялал жуулчлалын салбарт 25% нь 1-3 жил, 25% нь 2-6 жил, 25% нь 13-аас дээш жил, 12.5% нь 7-9 жил, 12.5% нь 10-12 жил тус тус үйл ажиллагаа явжуул ирсэн байгууллагууд хамрагджээ. Ажил олгогчдын хувьд 50% нь БНСУ, 43.8% нь Герман, Франц, 25% нь ОХУ, БНХАУ, Нидерланд, 37.5% нь АНУ, 31.3% нь Англи, 18.8% нь Япон, бусад улсууд эзэлж байна.

Зураг 13. Аялалын ачаалалтай саруудад Ойролцоогоор явдаг хөтчийн тоо?



Зураг 14. Хөтөч тайлбарлагч нарын хүний нөөцийг хаанаас



### 1.3 Сургалтын байгууллагын төлөөлөл

Судалгаанд 1, 16, 17 жил үйл ажиллагаа явуулж байгаа 3 байгууллагын төлөөлөл оролцсон болно. Өнгөрсөн хугацаанд нийт 3327 хөтөч тайлбарлагчийг бэлдэж гаргажээ.

Хөтөч тайлбарлагч нарт дараах төрлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг: Үүнд:


1. Аялал жуулчлалын ерөнхий ойлголт, мэдвэл зохих түүх, газарзүй, зан заншил, шашин, аяллын маршрутын мэдлэг, хөтчийн ур чадвар, үүрэг хариуцлага, анхан шатны тусламж үзүүлэх чадвар, хөтчийн ёсзүйг эзэмшүүлэх анхан шатны сургалт.
2. Ерөнхий мэдлэгийн сургалт, Эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх сургалт, Хууль эрх зүйн сургалт
3. 3-аас дээш жил тасралтгүй хөтчийн ажил хийсэн туршлагатай хөтчүүдэд зориулсан ахисан түвшний "Тур лидер" сургалт, харилцааны сургалт г.м

## **ХОЁР.ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧИЙГ СУРГАЖ, МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИХ ҮЙЛ ЯВЦ**

### **2.1 Мэргэжил эзэмшсэн байдал**

Дийлэнх буюу 44.8% нь хөтөч, тайлбарлагчийн сургалтанд хамрагдсан байгаа бол 25.4% нь аялал, жуулчлалын чиглэлээр их, дээд сургууль дүүргэсэн оролцогчид байна. Энэ нь хөтөч тайлбарлагчийг сургалтын төвүүд сургаж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэж байгааг харуулж байна. Мөн тал шахам хувь нь хөтөч тайлбарлагчийн гэрчилгээгүй байна.


*Зураг 15. Мэргэжил эзэмшсэн байдал (n=134)*



*Зураг 16. Гэрчилгээтэй эсэх (n=135)*


## Та хөтөч тайлбарлагчийн гэрчилгээтэй эсэх

135 responses




Мөн эдгээр оролцогчдын 98% нь мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх шаардлага байнга тулгардаг гэж хариулжээ.

Зураг 17. Танд мэдлэг, ур чадвар дээшлүүлэх шаардлага гардаг эсэх




Зураг 18. Сургалтын байгууллагууд хөтөч, тайлбарлагч нарт бүрэн дүүрэн сургалт өгч чаддаг уу?




Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

## Ажил олгогчдын сургалт зохион байгуулах боломж


Зураг 19. Хөтөч, тайлбарлагчийн дотоод сургалтын програмтай юу?



Зураг 20. Хөтөч тайлбарлагч нарын гарын авлагатай эсэх?



Зураг 21. Анхны тусламжийн сургалтанд жил бүр хамруулдаг уу?




## 2.2 Сургалтын байгууллагуудын үнэлгээ

Харин сургалт явуулж буй байгууллагын чанарыг 55 хувьтай, эргэх холбоог 64 хувьтай гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан респондентуудын хариултаас

мэдлэг, ур чадвар олгох, эргэх холбоог бусад салбарт явагдаж байсан ижил төрлийн судалгааны дүнтэй харьцуулахад маш сайн буюу хангалттай үнэлгээ өгсөн бөгөөд 45% нь хөтөч, тайлбарлагчийн сургалтад хамрагдсан байсныг энд онцлоё.

Өнөөдрийн үнэлгээгээр сургалтын байгууллагуудыг бүрэн дүүрэн сургалт өгч чаддаг гэж 55% нь хариулсан хэдий ч хөтөч, тайлбарлагчдийн хувьд монгол ёс, заншил, уламжлалын талаар түлхүү орох, практик ач холбогдлын үүднээс хөдөө айлд очиж бодитоор заах, морь унуулж сургах зэргийг сургалтын төлөвлөгөөнд оруулах зэрэг асуудлуудыг хөндсөн байсан билээ.



Судалгаанд оролцсон респондентуудын хувьд тус салбарын хамгийн сайн сургалт зохион байгуулдаг байгууллагуудыг нээлттэй байдлаар нэрлүүлэхэд дараах байдлаар үнэлгээ өгсөн байв.

1. Guide center – 18.5%
2. МХТХ- 17.2%
3. АЖХТ-12.5%
4. БОАЖЯ- 5.1%
5. Жуулчин ХХК-6.8%
6. Аялал жуулчлалын холбоо – 5.1%
7. New tour – 3.4%
8. Их, дээд сургууль 3.4%
9. МРТГА- 1.6%
10. Нoreca – 1.6%
11. Tour Agency – 1.6%
12. Тэмээн аялал – 1.6%
13. Мэдэхгүй -22%



## 14. Байхгүй -5.1%

### 2.3 Сургалтын хэрэгцээ, шаардлага

Судалгаанд оролцогчид цаашид ямар төрлийн аяллын мэдээлэл, мэдлэгээ илүү хөгжүүлэх хүсэлтэй байгаа талаар асуухад байгальд аялах, адал явдлын болон бизнес, ажил хэргийн төрлийн аяллын мэдээлэл авахыг чухалчилсан байна. Иймээс энэ төрлийн мэдлэг, мэдээллийг сургалтын хөтөлбөрт оруулах, сошиал орчинд мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна. Мөн урлаг, шашин, боловсрол, эрүүл мэндийн төрлийн аяллын мэдээллийг илүү танин мэдэх хэрэгцээ байгаагаа илэрхийлсэн байна.

Харин ур чадварын хувьд :


хамгийн доогуур үнэлгээ өгсөн

- манлайлан удирдах,
- үйлчлүүлэгчийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах,
- хууль эрх зүйн мэдлэгтэй байх ур чадвараа сайжруулах,

хамгийн хөгжүүлж сайжруулах ур чадваруудаар нэрлэгдсэн

- Жуулчнаа хөгжөөх сэтгэл зүйд суралцах
- Тайлбар бэлтгэх, хүргэх техникээ сайжруулах
- Анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зураг 23. Хөтөч тайлбарлагчийг ажилд авахдаа юуг гол болгож шалгаруулж авдаг вэ?



Тус ажил олгогчдын хувьд аялалын ачаалалтай саруудад 68.8% нь 20 хүртэл хөтөчтэй үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хөтөч шалгаруулж авахдаа зохион байгуулах ур чадвар /81.3%/, харилцааны соёл /81.3%/, хэлний түвшинг /75%/ хамгийн их харгалзаж үздэг гэжээ. Мөн морь унаж чадах эсэх, цагийн менежмент, ерөнхий мэдлэгийг харгалзаж үздэг байна.


**Сургалтын хэрэгцээг нэгтгэвэл:**

Ерөнхий мэдлэгийн хүрээнд	Аяллын төрлөөр	Ур чадварын хувьд /Хөтчийн өөрийн үнэлгээ болон ажил олгогчийн шалгуур/
Монголын түүх ба археологи	байгальд аялах	Манлайлан удирдах, зохион байгуулах ур чадвар
Байгаль ба ан амьтан	адал явдлын	Харилцааны соёл
Палентологи	бизнес, ажил хэргийн	Хэлний чадвар
Бичиг соёлын өв	урлаг	Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах
Газар зүй	шашин	Анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших
Ахуй, ардын зан заншил		Жуулчнаа хөгжөөх сэтгэл зүйд суралцах
Ёс зүйн код		Тайлбар бэлтгэх, хүргэх техникээ сайжруулах


*Зураг 24. Дээшлүүлэх шаардлагатай мэдлэг*

Танд дараах ерөнхий мэдлэгүүдээс алийг нь дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байгаа вэ?

135 responses



Зураг 25. Цаашид аялал жуулчлалын ямар төрлөөр мэдлэг мэдээлэлтэй болохыг хүсч байна вэ?




Зураг 26. Хамгийн сайн ур чадварууд

Та дараах ур чадваруудыг өөрийн зүгээс үнэлгээ өгч хамгийн сайн гэсэн 5 чадварыг сонгоно уу.




135 responses



Зураг 27. Зөвлөгөө авах, ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээ

Танд ямар ур чадвар, техникээ дээшлүүлэх, зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага байгаа вэ?

133 responses



## 2.5 Сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, асуудлууд

Сургалтын хөтөлбөрийн дундаж хугацааны хувьд үндсэн сургалт -21 хоног, хөтчийн сургалт 45 хоног, тур лидерийн сургалт -14 хоног, бусад сургалтууд 2-5 хоног байдаг байна.

Сургалтын төлбөрийн хувьд тус 3 байгууллагын хувьд Үндсэн сургалтын үнэ 330.000 төгрөг, Бусад сургалтын дундаж төлбөр 10.000-80.000 төгрөг, багагүй хувь нь үнэ төлбөргүй зохиогддог бол хөтчийн сургалт 380000 /Ковидын нөхцөлд 280 000/, Тур лидерийнх 200 000 тус тус төлбөртэй байна.

Зураг 28. Сургалтын агуулга, чиглэл хөтөлбөрийг боловсруулахад хөтөч тайлбарлагч, ажил олгогч нараас саналыг нь хэрхэн авдаг вэ?



Сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулахад санхүүгийн хувьд өөрийн сургалтын байргүй, түрээслэх шаардлага гардаг энэ нь сургалтын үнэд нөлөөлдөг. бүх зардлыг шингээвэл нэг хүнд ногдох төлбөр өснө. Мөн сургалтын байрны түрээс үнэтэй байдаг зэрэг оон асуудлууд тулгардаг гэж хариулсан байна.

Сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулахад ажил олгогч ААН-дийн зүгээс хамтран ажиллагч компаниудын хувьд "өндөр" шаардлага хангасан төгсөгчийг ажилд авах сонирхол бий. Сүүлийн 6-7 жилд компаниуд өөрсдөө "гадаад хэлийг нь шалгачихсан, ажилд авах сонирхолтой байгаа хүмүүс"-ээ манай төв рүү нэмэлт ур чадваруудыг сургахаар явуулдаг болсон. Ингэснээр хамтын ажиллагаа илт сайжирсан байна.

"...Сургалтын үйл ажиллагааг эрхлэн явуулахад салбарын яам, АЖХТ зэрэг төрийн байгууллагуудын зүгээс өнгөрсөн 16 жилийн хугацаанд яам, АЖХТ-өөс ямар ч дэмжлэг авч байсангүй, хамтран ажиллах санал ч ирж байсангүй. Харин эсрэгээрээ "үнэгүй" сургалтууд явуулж зах зээлээс "шахах" сонирхолтой байдаг гэж ойлгогддог. АЖХТ нь одоо "бүх сургалтыг манайх базна" гэсэн уриатай ажилладаг. Тэгэхээр сургалтын байгууллага болох юм бна гэж ойлгож байгаа. Цаашид хувийн хэвшлүүд нь яаж "амьдрах" ёстой вэ? гэдгийг ойлгохгүй байна. Мөн чанарт бус тоонд анхаардаг нь манай зарчимтай зөрчилддөг..." гэж сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын төлөөлөл үзэж байна.

Сайн хөтөч тайлбарлагч бэлтгэн гаргахад хөтчийн маш сайн туршлагатай, гадаад хэл дээрээ тайлбарлах, илэрхийлэх ур чадвар эзэмшсэн, мэдлэгээ байнга шинэчилж байдаг багш маш их шаардлагатай байдаг.

**Хөтөч тайлбарлагчийг бэлтгэх, ажлын талбарт хөдөлмөрлөх явцад сургалтын байгууллагуудын зүгээс ямар асуудалд онцгойлон анхаарч ажиллах ёстой байдаг вэ? гэсэн асуултанд хөтөч тайлбарлагчид дараах байдлаар хариулт өгчээ.**

- Монголын ёс заншилд сургах
- Аюулгүй байдал болон эмнэлгийн анхан шатны тусламж
- Практик сургалтаар хангах
- Хөтчийн гарын авлагатай болох
- Сургалтын агуулга болон чанар. Гадаад багштай байх.
- Заах арга барил сайн, сайн тайлбарлаж чаддаг өргөн мэдлэгтэй хүнийг багшаар ажиллуулах
- Монгол улсын түүхийг зөвхөн 13 дугаар зуун гэлтгүй сайн ойлгуулж эзэмшүүлэх Монгол ахуйн соёлын сайтар ойлгуулах Монголын түүх соёлыг багаас нь хөгжилтэй ойлгомжтойгоор ойлгуулж сургах
- Бүхий л талаас нь хамгийн түрүүнд "анхны тусламж" үзүүлэх хичээл сургалтыг маш нарийн заагаасай. Мөн ур чадвар техник
- Сургалтын хүрээнд морь унуулж сургах хэрэгтэй
- Чадавхижуулах
- Байнгын холбоотой байх
- Хөтөч тайлбарлагчийн хувийн соёл, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх
- Түүх, соёлын гүнзгий мэдлэгийг жуулчдад энгийн амархан ойлгуулах тайлбарууд
- Хамгийн түгээмэл ирдэг улсуудын ёс заншлын хамгийн наад захын жишээг дурдаж, тэднийг санаатайгаар болон санамсаргүй байдлаар дорд үзэхгүй байх сургалт заах хэрэгтэй байна
- Музейн тайлбар дээр дадлага хийлгэх мөн гол үзмэрүүдтэй танилцуулах дадлага хийлгэдэг байх
- Мэргэжлийн сургалтууд дутагдалтай байдаг, онолын болон практик. Хууль эрхзүй г.м Мөн залуу охидуудад биеэ хэрхэн авч явах талаарх тусгай зөвлөгөө сургалт маш хэрэгтэй. Миний танил охиныг жуулчин нь хүчиндсэн хэрэг гарсан боловч дараад өнгөрсөн
- Сургалтыг нь яг амьдрал дээр бодитоор заах хэрэгтэй юм шиг санагдсан. Ойрхон малчин айлд аваачаад монгол ахуйтай ойртуулаад, жуулчдын хамгийн их сонирхдог зүйлсийг танилцуулах г.м

- жолоочийг хариуцлагатай, шаардлага өндөр , мэргэшүүлэх
- Хөтөч тайлбарлагчийн ёс зүйн кодуудыг хөтөлбөртөө тусгах
- Мөн зарим нэг гэрээт малчид, морин аялалын ахлагч мэт нь маш бүдүүлэг, ёс зүйгүй, мөнгөний төлөө санагдсан. Тэдэнд ёс зүйн код, мэргэжлийн анхан шатны сургалтуудад бүрэн хамруулж байж хөтөчтэй гар нийлэн ажиллах боломжтой болно гэж боддог.
- Тогооч, жолооч, малчидын харилцааг сайжруулах

## ГУРАВ.ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧДЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ


Зураг 29. Та ажлын байрны мэдээллийг хаанаас авдаг вэ?



Судалгаагаар хөтөч тайлбарлагчдын дийлэнхи нь ажлын байрны зарыг танилуудаасаа буюу аяллын компаниудын сошиал орчинд тавигдсан зар, мэдээнээс авдаг гэсэн бол ажил олгогчид зар тавих /37.5%/, сургалтын төвүүдээс мэдээлэл авах /25%/, өөрсдөө дотооддоо сургаж авах /31.3%/ зэргээр хүний нөөцөө бүрдүүлдэг байна.

Зураг 30. Таньд үндсэн харьяалалтай аяллын компанитай байдаг уу?

Зураг 31. Байхгүй бол хэдэн компанитай хамтардаг вэ?



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн

Хөтөч, тайлбарлагчидийн 56.7% нь ямар нэг компанид харьяалагддаггүй байна. Аяллын идэвхитэй улиралд 31.3% нь хэд хэдэн компанид зэрэг ажилладаг гэсэн бол 20.1% нь хэд хэдэн ажлын гэрээгээр ажилладаг гэсэн байна.


Аяллын идэвхитэй улирлаас бусад улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, мөн тасалддаг учир хөтөч, тайлбарлагчид аль нэг компанийн харьяалалд байх сонирхолгүй, ач холбогдолгүй байдаг байна.

### 3.1 Цалин, урамшуулал


“...Хөтөчийн гарын мөнгө гэж хэлээд байгууллага өмнөөс минь авдаг...”

/Судалгаанд оролцогчдын санал хүсэлтээс/

Зураг 32. Та ажлын үр дүнгээр урамшуулал авдаг уу?



Зураг 33. Хэрвээ урамшуулал авч байсан бол хэрхэн үнэлж олгож байсан бэ?



Эх сурвалж: Түүвэр судалгааны үр дүн



Ажлын үр дүнгээс шалтгаалан 47.8% нь урамшуулал огт авч байгаагүй бол байнга урамшуулал авдаг гэх 9%-ийн респондентуудын 41.7% нь ажил олгогчийн тухайн үеийн шийдвэрээр, 24% нь гэрээнд тусгагдаагүй ч жуулчдын тухайн үеийн жуулчдын сэтгэл ханамжийн үнэлгээгээр, 8.3% нь гэрээнд нэмэлт үр дүнгийн урамшуулал заагдсаны дагуу тус тус урамшуулал авч байсан гэж хариулжээ. Мөн гарын мөнгийг компани аваад өгдөггүй байдал гардаг байна.

Урамшууллын орлогоос гадна цалингийн хэмжээг нээлттэй байдлаар тодруулахад туршлага багатай оюутан, туршлагатай хөтөч зэргээс шалтгаалан дараах хэмжээний цалин олгогддог бөгөөд судалгаанд оролцогчид бараг 10 жилийн өмнөх үнэлгээ хэвээр байгааг дурьдаад дийлэнхинь 20 хувь хүртэл нэмэх шаардлагатай гэжээ. Ажлын ачааллын хувьд орчуулга, хөтчийн ажлаа гүйцэтгэхийн зэрэгцээ зарим тохиолдолд өдрийн 2 удаа хоол хийх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг дангаараа хангаж ажиллах нь хамгийн хүндрэлтэй байдаг гэжээ.

**Нэг өдрийн цалингийн хэмжээ, үнэлгээ харьцангуй өөр байгааг харж болно. Үүнд:**

1. 50,000 төгрөг хүртэл 14.8%
2. 60.000-149.000 төгрөг хүртэл 46%
3. 150.000-300.000 төгрөг хүртэл 12.7%
4. 301.000-аас дээш 2.1%
5. Боломжийн цалинтай -12.7%
6. Хувиараа үнэ тохирдог – 10.6% тус тус хариулсан байна.

Ажил олгогчид өөрсдийн ажлын нэмэгдэл урамшуулалыг жуулчдын сэтгэл ханамжийн байдлаар нэмэх боломжтой гэж үзэж байв.


### **3.2 Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн байдал ба бусад даатгал**

Хөтөч, тайлбарлагч нарын тулгамдсан асуудлуудын хувьд нийгмийн даатгалын шимтгэл төлөлт санаа зовоосон асуудлын нэг байсан. Учир нь улирлын онцлогтой ажил учир ажилтай үеийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлж бусад үед тасалдуулах эсвэл огт төлөхгүй байдгаас үүдэлтэй зээл авах, зээлд хамрагдах боломж нөхцөл бүрдэхгүй, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд хүндрэл учирдаг талаар мөн 86% нь ямар ч дэмжлэг, туслалцаа авч байгаагүй гэж хариулсан байсан билээ. Харин ажил олгогчоос хөтчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлдөг үү? гэж тодруулахад 75% нь өөрсдийнх нь саналаар гэрээнд тусгаж шийддэг, 25% нь огт төлдөггүй гэж хариулсан


байна. Жуулчдын идэвхитэй улирлын үед буюу 5, 6, 7, 8, 9, 10 саруудад нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн компани төлөх бөгөөд бусад улиралд төлдөггүй байна. Иймээс хөтөч тайлбарлагчид зээлэнд хамрагдах боломж багасаж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт тасалдах, ажлын байрны тогтворгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй тус салбарт хүний нөөцийн хомсдол үүсэх нөхцлүүдийн нэг шалтгаан гэж үзэх үндэстэй байна.

Мөн судалгаанд оролцогч хөтөч нар хөдөлмөрийн гэрээнд гэнэтийн ослын даатгалд хамруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Харин судалгаанд хамрагдсан ажил олгогчид хөтөч тайлбарлагчдыг даатгуулсан байдлаас харахад гэнэтийн ослын болон мэргэжлийн хариуцлагын даатгалд 3, ямар нэг даатгалд хамруулаагүй 7, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд 1, мэдэхгүй 1, сайн дурын даатгалд 1 тус тус хамруулсан байдалтай байна.

Зураг 34. Ажил олгогч хөтөч, тайлбарлагчийн НДШ төлдөг эсэх




Зураг 35. Таны нийгмийн асуудлыг тухайлбал эрүүл мэндийн асуудал тулгарах, орон сууц, автомашин худалдан авах, сургалтын төлбөр төлөх зэрэгт гэрээтэй байгууллагаас дэмжлэг туслалцаа үзүүлж байсан уу?



Респондентуудын 86% нь ямар нэг байдлаар албан байгууллагаасаа дэмжлэг, туслалцаа авч байгаагүй бөгөөд 30.6% нь хувиараа нийгмийн даатгалаа төлдөг гэжээ.

Зураг 36. Таны нийгмийн даатгалын төлөлт хэрхэн төлөгддөг вэ?



### 3.3 Ажлын хэрэгцээний хангамж

Хөтөч тайлбарлагчдын зүгээс дараах зүйлсийг хамгийн их шаардлагатай хангамж байх ёстой гэж нэрлэсэн байна:

1. Утасны жагсаалт, лавлах, толь бичиг, бүх төрлийн гарын авлага Морь унах аюулгүйн гарын авлага, German, Орос, англи, Солонгос, Япон~Монгол хэл дээрх гарын авлага Өвс ургамал, амьтдын гарын авлага – 24%
2. GPS – 10.1%
3. Байхгүй - 1.2%
4. Аппарат, камер, цаг, утас, машин, интернет, таб, микрофон, power bank, луужин, аюулгүйн тоног хэрэгсэл, мишок – 16.5%
5. Мэдэхгүй -3.8%
6. Бичгийн хэрэгсэл - 2.5%
7. Аялалын хувцас, уулын, усны хамгаалалтын, морины гэх мэт - 24%
8. Анхны тусламжийн эмийн сан - 3.8%
9. Газрын зураг – 8.8%
10. Музей болон сүм, хийдийн план зураг – 1.2%
11. Зөөврийн проектор - 1.2%
12. Цахим апп – 1.2%
13. Жуулчидад зориулсан аяны 00 – 1.2%

Дээр дурьдагдсанаар хөтөч, тайлбарлагч нарын тулгамдсан асуудалд шаардлагатай ажлын багаж, тоног төхөөрөмж, гарын авлагаар хангадаг байх гэж дийлэнх нь буюу 24% нь хариулсан ч ажил олгогч тал 43.8% нь гарын авлагатай, 25% нь хийхээр төлөвлөж байгаа харин 31.3% нь ямар нэг гарын авлага байхгүй гэжээ. Хөтөч тайлбарлагч нарын хувьд сайн мэдээлэл бүхий, олон талын мэдлэг олгох гарын авлагатай байх маш чухал гэдгийг онцолсон байв. Иймээс ажил олгогч тал утасны жагсаалт, лавлах, толь бичиг, бүх төрлийн гарын авлага, морь унах аюулгүйн гарын авлага, Герман, Орос, англи, Солонгос, Япон ~ Монгол хэл дээрх гарын авлага, өвс ургамал, амьтдын гарын авлага гэх мэт шаардлагатай мэдээллийн сан бүхий сайн чанарын гарын авлагатай болох шаардлага тулгарч байна.

Хөтөч тайлбарлагч ажил гүйцэтгэхэд нь зориулж ажилд шаардлагатай хэрэгсэлүүд, явуулын эмийн сан, чанга яригч, ажил гүйцэтгэх явцад шаардлагатай бэлэн мөнгө, ажлын хувцас, аяллын үеийн өдөр тутмын хэрэглээг нь бэлдэж өгөх, шаардлагатай багаж хэрэгсэлээр хангадаг гэж судалгаанд оролцсон ажил олгогчдын 66%, ямар нэг зүйлээр хангадаггүй 20%, цалин урамшуулал олгодог 13.3% нь хариулжээ.

### **3.7 Хөтөч тайлбарлагчийн хөдөлмөрлөх эрх зүйн орчин**

#### **3.4.1 Ажлын байрны тодорхойлолт**

Аялал жуулчлалын тухай хуулинд *"хөтөч-тайлбарлагч"* гэж аялал жуулчлалын хөтөлбөрийн дагуу жуулчинд газарчлан, орчуулга, тайлбар хийх хувь хүнийг хэлнэ" гэж тодорхойлсон байна.

Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газрын үндэсний ажил, мэргэжлийн ангилалд хөтөч тайлбарлагчийн ажлын байрыг тодорхойлохдоо: *"Гадаад хэл, түүх, байгалийн ухаан, газар зүйн мэдлэгтэй, тайлбарлан таниулах, хүнтэй харилцах, экологийн боловсролтой, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, удирдан зохион байгуулах ур чадвартай байх"* гэж тусгажээ.

*Аялал жуулчлалын тухай хуулийн 12,13 дугаар зүйлд:*

#### **Хөтөч-тайлбарлагчид тавигдах шаардлага:**

1. Монгол Улсын иргэн байх;
2. нэг буюу түүнээс дээш гадаад хэл эзэмшсэн, хөтөч-тайлбарлагчийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;
3. хөтөч-тайлбарлагчийн үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн хувьд тэнцсэн байх.

## Хөтөч-тайлбарлагчийн эрх, үүргийг

1. аялал жуулчлалын тухайн байгууллагаас баталсан хөтөлбөрийн дагуу жуулчдад үйлчлэх, тэдний аюулгүй байдлыг урьдчилан сэргийлж, хангуулах;
2. жуулчдад үйлчилж байх хугацаандаа аялал жуулчлалын тухайн байгууллага болон өөрийн нэр бүхий хөтөч-тайлбарлагчийн тэмдгийг ил зүүх;
3. Монгол Улсын нийгэм эдийн засаг, төрийн байгуулал, байгаль, түүх, соёл, ард түмний зан заншлын талаар жуулчдад бодит мэдээлэл өгөх, улс, хувь хүн, байгууллагын нууцад хамаарах мэдээллийн нууцыг задрлуулахгүй байх;
4. үйлчилгээнийхээ явцад өөрийн буруугаас жуулчинд болон аялал жуулчлалын тухайн байгууллагад учруулсан хохирлыг арилгах.

Үүрэг: Хөтөч-тайлбарлагч нь жуулчдаас шан харамж шаардах, аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

### 3.4.2 Хөдөлмөрийн гэрээний анализ

Хөтөч тайлбарлагч ба ажил олгогч талуудын байгуулсан 2 гэрээг кейс болгон анализ хийхэд ажлын байрны тодорхойлолтыг бүрэн тусгадаггүй, гэрээнд гүйцэтгэгч тал буюу хөтөч тайлбарлагч талуудын эрх дутмаг, үүрэг хангалттай их байхаар тусгагдсан байна. Тухайлбал доорхи гэрээнд компаний эрх үүрэг бүхий заалт 6, хөтөч тайлбарлагчийн эрх үүрэг бүхий заалт 18, мөн хөтөч тайлбарлагчийн хориглох зүйлс гэсэн нэмэлт бүлэгт 9, хариуцлага гэсэн бүлэгт зөвхөн хөтөч тайлбарлагчид хамааралтай 2 заалт тусгагджээ. Энэ нь ажил олгогч талын эрх үүргийг давамгайл тусгаж, нэг талын эрх ашгийг хамгаалсан, хариуцлага хүлээх тэгш бус шинжтэй байх бөгөөд хөтөч тайлбарлагчийн үйл ажиллагаанаас аль болох алдагдал хүлээхгүй байхаар бүрэн дүүрэн хариуцлагын заалтыг оруулсан нийтлэг хандлагатай байна.

Судалгаанд хамрагдсан ажил олгогчид аяллын явцад хариуцлага алдсан хөтөч тайлбарлагчид анхааруулга, сануулга өгдөг гэж 31%, ажлаас халах 19%, цалин хасах 43%, алдаанаас шалтгаалан шийднэ 6.2% ажил олгогч хариулжээ.

Хөтөч тайлбарлагч нар урьдчилгаа төлбөр авч хувийн бэлтгэлээ хангах, гарын мөнгө урамшуулал авах, ажлаа дүгнүүлэх, нэмэлт бонус авах талаарх заалт томоохон ААН-дийн байгуулдаг гэрээнд хүртэл бүрэн дүүрэн тусгагдаж чаддаггүй байна.

Хөтөч тайлбарлагчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, гүйцэтгэх үүрэгт ажлыг гэрээнд тодорхой зааж ялангуяа аяллын компаний менежер, жолооч, тогооч нарын ажил үүргийг уялдуулж тусгах, бусад үйлчилгээний байгууллагууд, гэрээтэй ажиллах малчин айл, бааз, ресторан, музей, хийд зэрэг жуулчинд хамаарах бүхий л байгууллагатай компаниас гэрээ байгуулдаг, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэн хамтран

ажиллах боломжийг бүрдүүлэх шаардлагатай гэжээ. Түүнчлэн эмнэлгийн тусламж үзүүлэх эмнэлэг, цагдаа, банкны ажилчдын үйлчилгээг салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд шуурхай, соёлтой болгох ажил хийх санал дэвшүүлжээ.

#### Хоёр. Компанийн эрх, үүрэг

- 2.1 Ажилтныг ёс зүй болон мэргэжлийн өндөр түвшинд жуулчинд баталж өгсөн хөтөлбөрийн дагуу орчуулга, газарчлах болон тайлбар хийхийг шаардах эрхтэй.
- 2.2 Ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгтэй нь холбогдсон заавар зөвлөгөө тодорхой өгч, ажил үүргийг нь оновчтой зохион байгуулна.
- 2.3 Хэрэв Жуулчнаас Ажилтны талаар гомдол мэдээлэл ирүүлсэн бол үүнийг энэхүү гэрээнд заасан үндэслэл журмын бие даан шийдвэрлэх эрхтэй.
- 2.4 Ажилтанд ажилласан хоног тутамд нэг өдрийн хөлсийг НДШ болон ХАОАТ-ын хувийг суутган тооцсон компанийн баталсан орчуулагчийн тарифын дагуу аялал бүрийн дараа төгрөгөөр тооцон олгоно.
- 2.5 Ажилтанд тухайн аяллын төрлөөс хамаарч ажилласан хоног тутмын өдрийн хөлсийг зэрэглэл бууруулан болон өсгөн тооцон олгож болно.
- 2.6 Жуулчныг тосох үдэх цаг нь өглөөний 07.00 цагаас өмнө болон оройн 22.00 цагаас хойш байвал тухайн тээврийн хэрэгслийн овор хэмжээнээс шалтгаалан боломжит газраасаа авхуулах болон хүргүүлнэ. /Дээр дурдсан цагт хамаарахгүй бол орчуулагч, жолооч хоёр компани дээр уулзаж жуулчны үйлчилгээ эхэлнэ/

#### Гурав. Ажилтны эрх, үүрэг

- 3.1 Ажилтан нь компанийн Борлуулалтын албаны удирдлага дор батлагдсан хөтөлбөр, томилсон хугацаанд жуулчинд үйлчилнэ.
- 3.2 Ажилтан нь аялал буюу үйлчилгээнд гарахаас өмнө Зах зээл хариуцсан менежерээс аяллын хөтөлбөр, аялагчдын үнэлгээний хуудас “Tour evaluation” Бааз, ресторан, буудлын үнэлгээний хуудас болох “Хөтөч орчуулагчийн аяллын тайлан” авах, санхүүгийн албанаас тухайн аялалд шаардлагатай ваучер болон аяллын хөтөлбөрийн дагуу шаардлагатай бэлэн мөнгийг “Бэлэн мөнгө хүсэх өргөдөл”-р авах, үзвэр үйлчилгээний газрууд, үйлчлэх унааны захиалгуудыг тулгаж нягтлан баталгаажуулж, бэлтгэлийг хангасны дараа ажилд гарах үүрэгтэй.
- 3.3 Нисэх онгоц, галт тэрэгний буудал дээр жолоочийн хамт зочны ирэх ёстой цагийн хуваариас 20-30 минутын өмнө очиж жуулчинд харагдахуйц газрыг сонгон компанийн нэр, лого бүхий зочны нэр (Групп жуулчдын хувьд туг)- ийг барьж компанийн лого бүхий дүрэмт хувцас өмсөж, энгэрийн тэмдэг зүүн угтана.
- 3.4 Жуулчдад хөтөлбөрийг танилцуулж, тодотгол хийх /нэмэлт өөрчлөлт, ойлголтын зөрүү байвал/ шаардлага гарвал аялал хариуцсан менежер болон захиалга үйлчилгээний албанд мэдэгдэж шуурхай арга хэмжээ авхуулна.
- 3.5 Аялалд гарахаас өмнө орон нутгийн нислэг, гал тэрэгний билетийг тухайн аялал хариуцсан менежерээс авна.
- 3.6 Аяллын батлагдсан хөтөлбөрийн дагуу жуулчинд үйлчлэх ба тухайн жуулчны бааз зочид буудал, үзвэрийн газар, байгууллагатай байгуулсан гэрээний заалт болон тухайн аж ахуйн нэгжийн дүрэм журмыг мөрдөн ажиллана.
- 3.7 Зочид буудал, жуулчны баазууд, үзвэрийн газарт үйлчилгээний талаар шаардлага тавьж, газар дээр нь зохион байгуулахын зэрэгцээ гарсан зөрчлийн талаар тухайн байгууллагын менежер болон зохион байгуулагчид танилцуулж, тэр тухай хөтөч орчуулагчийн аяллын тайланд тэмдэглэл хийх ба эдгээр газруудыг уг “Хөтөч орчуулагчийн аяллын тайлан”-гаар үнэлнэ. Үйлчилгээний доголдол зөрчилтэй бол зургаар болон бичгээр хавсаргана.
- 3.8 Жуулчинд үйлчлэх жолоочид мэдээлэл зөвлөгөө өгч, үйлчилгээний горим сахиулж, зөрчил дутагдал гаргахгүй байхыг хариуцна. Жолоочийн замын хуудсыг зөвхөн хөтөлбөрийн дагуу ажилласан хэмжээгээр бензин шатахуун, явсан км/цагийг үнэн зөв тодорхой бичиж тэмдэглэнэ. Техникийн гэмтэл гарсан жолооч товлосон цагаас хожимдсон зэрэг саатал доголдлыг хариуцсан аялал хариуцсан менежер болон тээврийн албанд мэдэгдэж, жолооч болон машиныг солих хүртэл санал тавьж шуурхай арга хэмжээ авхуулна.
- 3.9 Жуулчны тав тухтай болон аюулгүй байдал, ялангуяа эд юмс, мөнгө, бичиг, баримтыг хулгайд алдахаас урьдчилан сэргийлж, хэлж сануулах болон давхар хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.10 Хүлээн авч үйлчлэх жуулчны холбогдолтой мэдээллийг тухайн аяллыг хариуцсан менежерээс амаар болон бичгээр авна.

- 3.11 Үйлчилгээний явцад компанийн ажилтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж дутагдал зөрчил гарч, зочны зүгээс гомдол гаргасан тохиолдолд компанийн удирдлагад танилцуулж, шуурхай арга хэмжээ авхуулна.
- 3.12 Аяллын тооцоог ажлын 3 хоногт багтаан Санхүү бүртгэлийн албанд тооцоо нийлнэ. Ажилтан дараалсан аялалтай тохиолдолд аялал хариуцсан менежерт хүлээлгэн өгнө.
- 3.13 Аяллын үнэлгээний хуудсыг /tour evolution- Сэтгэл ханамжийн судалгааг / тухайн аяллын нийт жуулчдын 75-с дээш хувиар бөглүүлсэн байна.
- 3.14 Ваучерын хөтчид үлдэх хувь дээр харилцагчийн гарын үсгийг заавал зуруулна
- 3.15 Үйлчилгээнд гарсан ямарваа нэгэн санаатай болон эс санаатай гомдол дутагдлыг Хөтөч орчуулагчийн аяллын тайланд үнэн зөвөөр тэмдэглэж компанийн удирдлагад танилцуулна.
- 3.16 Хөтөч орчуулагчийн гарын авлагыг мөрдлөг болгон ажиллана.
- 3.17 Компанийн гэрээ хэлцэлийн нөхцөл, төлбөр болон худалдаа зах зээлийн холбогдолтой мэдээллийн нууцыг хадгална.
- 3.18 Хөтөч тухайн аялалд явах боломжгүй болсон тохиолдолд аялал гарахаас 5 өдрийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

#### Дөрөв. Ажилтанд хориглох зүйлс

- 4.1 Компанийн зөвшөөрөлгүй дур мэдэн хөтөлбөрт өөрчлөлт оруулах болон түүний өмнөөс аливаа шийдвэр гаргахыг хориглоно.
- 4.2 Жуулчинтай харилцахдаа соёлгүй бүдүүлэг байдал гаргах, шан харамж горьдох зорилгоор дарамт үзүүлэх, зөвшөөрөлгүй аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зэрэг үйлдэл оролдлогыг хатуу хориглоно.
- 4.3 Жуулчинд үйлчлэх үед шаардлагатай бус бол утас хэрэглэх, бохь захлах зэргийг хориглоно.
- 4.4 Жуулчдыг хөтөлбөрт заасан дэлгүүр үйлчилгээний газруудаар үйлчлүүлэх ба өөрийн зүгээс хөтөлбөрт заагдаагүй дэлгүүр орохыг санал болгох, дэлгүүр оруулсны дараа орчуулагч, жолоочийн хувийг жуулчдын дэргэд авах, жуулчидтай эрх ашгийн зөрчилдөөн гаргахыг хатуу хориглоно.
- 4.5 Хөтөч орчуулагчийн аяллын тайланг үнэн зөв тайлагнах үүрэгтэй бөгөөд хуурамчаар үйлдэхийг хориглоно.
- 4.6 Үйлчилгээний үеэр ажлаас хожимдох, хуваарьт үзвэр үйлчилгээгээр болон жуулчны тээврийн хэрэгслээр гаднын хүмүүст үйлчлэхийг хориглоно.
- 4.7 Үйлчилгээний үеэр согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хатуу хориглоно.
- 4.8 Хөтөч-тайлбарлагч нь үйлчилгээний үед жуулчинтай болон харилцагч байгууллагатай тогтоосон ажил төрлийн хэлхээ холбоог хувийн эрх ашигт ашиглахыг хориглоно.
- 4.9 Харилцагч байгууллага болон хувь хүмүүстэй ёс зүйгүй бүдүүлэг харилцах, гэрээнд зааснаас илүү шаардлага тавихыг хориглоно.

#### Тав. Хариуцлага

- 5.1 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг, хориглосон зүйлсийг зөрчсөн нэг дор 1-2 зөрчил гаргасан тохиолдолд түүнд олгох ажлын хөлсний 10%, нэг дор 3-4 зөрчил гаргасан тохиолдолд ажлын хөлсний 15%, нэг дор 5 болон түүнээс дээш зөрчил гарсан тохиолдолд ажлын хөлсний 20%-ийг хасаж тооцох ба зөрчил давтан гаргавал Компани гэрээг бие даан цуцлах үндэслэл болно.
- 5.2 Үйлчилгээний явцад өөрийн буруугаас жуулчинд болон Компанид хохирол учруулбал түүнийг бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

Хөтөч тайлбарлагчид ажил гүйцэтгэх гэрээнд ажлын байрны тодорхойлолтыг илүү тодорхой тусгах, , эрх үүрэг, үндсэн цалин, нэмэлт урамшуулал, үнэлгээ, сургалт , ажлын хэрэгцээний зардал хангамж, нийгмийн асуудлыг шийдэх зэрэг талаас дараах байдлаар тодорхой тусгуулах шаардлагатай гэж хариулжээ.

1. Цалин, урамшуулал нэмэх, хээрийн нэмэгдэл олгох -20.7%
2. Сургалт – 18.9%
3. Даатгалд албан ёсоор хамруулах, аюулгүй байдлыг хангах – 16.9%
4. Нийгмийн асуудалд анхаарах – 13.2%
5. Ажлын хэрэгцээний зардал олгох – 11.3%

6. Ажлын багаж, тоног төхөөрөмжөөр хангах – 5.7%
7. Аялалд гарах, ирэхэд унаагаар хүргэж, авдаг байх – 3.7%
8. Бүх талаар л хамтран ажиллах 1.9%
9. Жуулчны хүсэлтээр төлөвлөөгүй үйл ажиллагаа явуулах, зардал гаргах бол хэрхэн шийдэх талаар тусгах 1.8%


### 3.4.3 Хөтөч тайлбарлагчийн ангилал зэрэглэл, эрхийн үнэмлэх, мэргэжлийн индекс

#### Хөтөч тайлбарлагчийн зэрэглэл тогтоох талаарх байр суурь:

Зураг 37. Зэрэглэлтэй болгох ыг дэмжих эсэх

Хөтөч тайлбарлагч нарыг зэрэглэлтэй болгох шаардлага байгаа гэдэгтэй санал нийлж байна уу?

135 responses



Хөтөч тайлбарлагч нарын хувьд

1. Эхлээд хуулийн шинэчлэлээ батлуулаад, хуулинд мэргэжлийн үнэмлэхгүй бол хөтөч хийж болохгүй гэж оруулах, дараа нь стандартаа ярих, түүний дараа ангилал, зэргийн асуудлыг хөндөх, буруу болон олон ангилж зэрэглэл тогтоовол маш хортой, зэрэглэл тогтоохын тулд шалгаруулна, ур чадвар ажлын байран дээр илрэх тул урьдчилан ярилцлага тэстээр шалгах боломжгүй зүйл гэсэн үзэлтэй болгоомжилсон хэсэг
2. Сургалтаа төгсөхөд нь эрх олгоод үнэмлэхжүүлэх, дараа нь зэрэглэл тогтоох, цалингийн тогтолцоог уялдуулах, сургалтын төв зэрэглэл тогтоох ажлыг гүйцэтгэх гэсэн хэсэг




3. Дийлэнхи нь зэрэглэл тогтоох шаардлагатай гээд дараах шалгуураар тогтооё гэсэн хэсэг. Мөн үүн дотор одоо байгаа хөтөч тайлбарлагч нараа компаний үнэлгээ, ажилласан жилээр нь шууд тогтооё, ёс зүй, мэргэжлийн алдаа гарвал хураадаг болох, ерөнхий ба тусгай гэсэн чиглэлээр мэргэшүүлэх нь зөв гэсэн хэсэг байна. Шалгуурын тухайд:

1. Ажлын туршлага, ажилласан жил
2. Мэргэжлийн ур чадвар
3. Жуулчны сэтгэл ханамжийн оноо
4. Мэдлэгийн түвшин
5. Хэлний түвшин
6. Сургалтанд хамрагдсан байдал
7. Ёс зүй, харилцааны соёл, хандлага гэсэн шалгуурыг дурьдсан байна.

### **Зэрэглэл ангилал тогтоох талаар ажил олгогчын байх суурь:**

Өмнөх ангилал зэрэглэлийн тогтолцоо нь ААН-ийн санал бодлыг тусгаагүйн улмаас хэрэгжээгүй гэж ажил олгогчид үзэж байна. Улсаас хөтөч тайлбарлагчийн зэрэглэл олгохыг ажил олгогчдын 93.8% нь тогтоох шаардлагатай гэж хариулсан байна.

Зураг 38. Улсаас Хөтөч тайлбарлагчийн зэрэглэл олгох шаардлагатай эсэх



- Бодит, хүрэхүйц, үр дүнтэй байх...улирлын чанартай тул ихэвчлэн оюутнууд хийдэг өндөр мэдлэг боловсролтой хүмүүс мэдээж тогтмол ажил хийхийг илүүд үздэгийг бодолцож уян хатан хандах нь зөв байх
- Аялал жуулчлалын байгууллага тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдагтай адил хөтөч нар тусгай үнэмлэхээр хөтөчийн ажлыг хийвэл зохистой. Хэлний мэдлэг ,ерөнхий мэдлэг, чадвараар ангилан үнэмлэх олгох,

ажлын туршлагаа ахиулан цаашдаа зэрэглэлээ дээшлүүлэх боломжтой байх хэрэгтэй. Тухайн тогтоосон зэрэглэлийн дагуу хөтөч нарыг хуваарьлах аяллын төрлийг сонгоход дөхөм болно гэж найдаж байна.

- Хөтөч хүний мэдэх ёстой бүх мэдлэгийг олгон маш сайн шалгалт авах хэрэгтэй. Жишээ нь түүхээ мэдэхгүй, олдворуудаа тайлбарлж чадахгүй, ёс заншлаа мэдэхгүй, хөтөч нар маш их. Дээр нь хариуцлага болон ёс зүй байхгүй
- Эхний шатанд гайд нараас гайдын эрх, үүрэг, ёс зүй, ерөнхий мэдлэгийг шалгасан тест авах. Тестийн шалгалтаар тэнцсэн гайдуудыг ярилцлагын шатанд оруулах. Ярилцлагын шат нь дараах хэсгүүдтэй байж болно. 1. Гадаад хэлний мэдлэг 2. Түүх, соёл, газар зүйн мэдлэг 3. Асуудал шийдвэрлэх (кейс өгөх) 4. Анхны тусламжын мэдлэг (кейс өгөх)
- соёлын, түүхийн, адал явдалт, тусгай сонирхлын гэх мэт тодорхой категорит хуваан онцлогоос нь хамаараад дотор нь 1 2 3 гэж ангилж болох юм.
- 1. Анхан 2. Дунд 3. Мэргэшсэн 4. Дээд 5. Төгс гэх мэт ангилалтай байх нь илүү оновчтой гэж үзэж байна.

### **Зэрэглэл тогтоох талаар сургалтын байгууллагуудын байр суурь:**

Энэ удаа хөтөч тайлбарлагчдад ангилал зэрэглэл тогтоож, эрхийн үнэмлэх олгох ажлыг эхлүүлэх хэрэгтэй. Ангилал зэрэглэл тогтоож олгох нь хөтчүүдийг чанаржуулах, ёс зүйтэй байлгахад хэрэгтэй талаар судалгаанд оролцсон сургалтын байгууллагын төлөөлөл дурьджээ. Мөн эрх олгох ажлын дараа зэрэглэлийг нарийн судалгаатайгаар эхлүүлсэн нь дээр гэсэн байр суурьтай байна.

Хөтөч тайлбарлагчийн ангилал зэрэглэлийг хөтчийн сургалтанд голлох үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудын удирдлага, гол багш нарыг оролцуулан "Улсын комисс"-ыг шударга байгуулах, комисс нь зэрэглэл тогтооход шаардлагатай журмуудаа боловсруулах, жилд нэг удаа зэрэглэл тогтоох шалгалтыг зохион байгуулах, 2-оос дээш жил хөтөч хийсэн хөтчүүдийг хамруулах, улсын комиссын бүрэлдэхүүнд яамнаас оролцох шаардлагагүй, АЖХТ-өөс ганц төлөөлөл байж болно. Зочлох үйлчилгээний чиглэлийн багш нар байх ёсгүй. Хүлээн зөвшөөрөгдсөн, аялал жуулчлалын салбарт танигдсан туршлагатай бүрэлдэхүүн ажиллах ёстой. Зэрэглэл тогтооход бидэнд суурь болгох мэдлэгийн бааз хэрэгтэй. Үүнгүйгээр хөтчийн мэдлэгийг хэмжих, түүнд зэрэглэл тогтоох боломжгүй, энэ бааз нь одоохондоо байхгүй байна. Үүнийг хамгийн түүрүүнд хийх хэрэгтэй байна.

Одоо үйлчилж байгаа мэргэжлийн индекс ерөнхий байгаа, бас шинэчлээгүй их удлаа. Мэргэжлийн индексгүй болгосон байсныг буцаагаад бий болгосон байсан.


### 3.5 Ковид ба хүний нөөцийн шилжилт

Хөтөч тайлбарлагчийн ажил нь ихэвчлэн улирлын чанартай байдаг тул аяллын бус саруудад тэд дараах ажлуудыг голчлон эрхэлж, нэгдсэн бодлогоор ажилд зуучлахад туслахыг хүссэн байна.

1. Орчуулагч
2. Хувиараа болон сургалтын төвд багшлах
3. Зохион байгуулагч, менежер
4. Хүний нөөц, оффисийн бичиг хэргийн ажилтан зэрэг ажлуудыг дийлэнх нь эрхэлдэг байна.

Судалгаанд оролцсон хөтөч тайлбарлагч нарын 70 гаруй хувь нь цар тахлын энэ хүнд үед мэргэжлээ сольж зарим нь жуулчны баазад цагаан хэрэглэл дээр ажиллаж байгаа тухай дурьдсан байна. Мөн 3 хөтөч тутмын нэг нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж, 20 хувь нь бусад салбарт ажиллаж байна.

Зураг 39. Ковидийн үеийн ажил эрхлэлтийн байдал



Ойрын 3 жилд хөтөч тайлбарлагч нар 10 хүртэл шаардлагатай байна гэж 4 ажил олгогч, 10-20 хүртэл гэж 2 ажил олгогч, 150 хөтөч хэрэгтэй гэж 1 ажил олгогч, цар тахлын улмаас захиалга аваагүй гэж 1 ажил олгогч, гадаад хэлний мэдлэг тус бүрээр англи хэлний гайд 15-20, Герман хэлний гайд 5-8, Франц хэлний гайд – 5, Япон хэлний гайд 5-8, Солонгос хэлний гайд -10 тус тус шаардлагатай гэж хариулсан байна.

### **3.6 Тулгамдсан асуудлын шинжилгээ**

#### **3.6.1 Хөтөч тайлбарлагчаар ажиллахад ажил олгогчтой холбоотой тулгамдсан асуудал, бэрхшээл**

- Жилийн 4 улирал ажилтай байх
- НДШ-ийг бүтэн жилээр төлдөг болох
- Хөтөчийн нэрээр жуулчдаас гарын мөнгө хураалгаж авдаг гэвч тэр хөтчүүдэд очих биш аяллын зардалд шингэдэг
- Хөтөчийн гарын мөнгө гэж хэлээд байгууллага өмнөөс минь авдаг
- Цалин бага байдаг
- Туршилт, дадлагын аялал хийлгэлгүй шууд жуулчидтай аялалд гаргадаг
- Гэнэтийн ослын болон ямар нэг даатгал байдаггүй
- Хөдөлмөрийн гэрээ хийдэггүй
- Шахуу хөтөлбөр өгөөд түүнийгээ зохицуулахыг шаарддаг
- Тодорхой мэдээлэлгүй ажиллуулдаг
- Гэнэтийн хуваарь өөрчлөлт гардаг, бүх ажлаа төлөвлөчихсөн байхад гэнэт дуудах, эсвэл хугацаанаас өмнө дуусгах гэх мэтийн хуваарийн өөрчлөлт их байдаг
- Зарим аялалд өөрөөс гарсан зардалыг компани гаргаж өгдөггүй. Бас осолд орсон байхад ажлын хөлсийг бүрэн өгөөгүй тохиолдол байдаг
- Зарим газар (хөдөөний) худалдана авалт хийхэд одоо болтол ebarimt хэрэглэдэггүй байдал төлбөр тооцоо дээр асуудал болдог. Учир нь компани ebarimt-аар баталгаажсан баримт нэхдэг.
- Хамгийн анх аялалд явсан компани маань хөдөө явангуут мартчихсан. Эргэж холбогдож заавар зөвлөгөө авах боломжгүй байсан.

- Засгийн газраас бодлогоор энэ салбарыг хөгжүүлэхгүй бол үзэж харах зүйл бараг байхгүйтэй адил, боловсон жорлон ч олдохгүй, дэд бүтэц муутай, Монголын байгаль гайхамшигтай биш шүү дээ үнэндээ, дээрээс нь бохир заваан, байгальд хүн 3 хоноод л уйддаг, тиймээс жуулчин хүлээж авдаг бааз, буудал, газруудын шаардлагыг дэлхийн стандарт хангасан тохилдолд л зөвшөөрлийг нь олгодог байх хэрэгтэй, дэмждэг байх
- Зарим газрууд тодорхой удирдамж өгөхгүйгээр тийшээ тэд хононо гээд л явуулчихдаг. Тухайн хүн ямар зорилготой юу үзэж харах сонирхолтой талаар ямар ч баримжаагүй хөтөлбөргүй явуулдаг тохиолдол бий. Мөн хээрийн хоолны асуудал жижиг компаниудад асуудал үүсгэдэг.
- Хөдөлмөрийн үнэлэмж багатай санал тавьдаг
- Үзмэрийн талаар нарийн мэдээлэл өгдөггүй
- Зарим тохиолдолд жолоочийн хоол ба байрлах хэрэгслийн талаар мартдаг
- Жуулчдад "гарын мөнгө"-ний тухай мэдээлэл огт өгөөгүй байсан тохиолдол бий
- Жуулчны компаниуд олон жилийн өмнөх мэдээлэл, маршрут энэ тэрээ засдаггүй, өнөөхийг нь залруулах гэж их юм болдог.
- жуулчдаас өгсөн гарын мөнгийг компани авдаг, солонгос эзэнтэй компани учир улсад бүртгэлгүй, улсад татвар өгдөггүй.
- Хамгаалах хувцас хэрэгсэл, ажлын шаардлагатай хэрэгслээр хангадаггүй. Жич: (морь унахад) Майхан ус нэвтэрдэггүй байх г.м

### **3.6.2 Хөтөч, тайлбарлагчийн болон жуулчдын хувьд тулгамдсан асуудлууд**

- Хувийн аюулгүй байдал
- Хөдөө орон нутагт Toilette, ОО-ийн асуудал маш хүнд
- Хөдөө, орон нутгийн Camp-ийн хүмүүс нь англи хэлтэй байх, харилцааны асуудал
- Жолооч нарын дийлэнх бүдүүлэг, хувиа хичээсэн, ажлын ухамсар муутай байсан.
- Морин аялал зэрэгт ямар 1 осол гархад тохиолдолд аялалын компанийн зүгээс хариуцлага хүлээх, хөтөч тайлбарлагчдыг хамгаалах дүрэм журам байдаггүй. Эрүүл мэндийн, эрсдэлийн даатгалд компанийн зүгээс заавал хамруулах шаардлагатай байна.

- Адуучид мөнгө олох талаар бодохоос биш, эрсдэлийг огт бодож үздэггүй. Мориноос унаж гэмтсэн болон моринд чирэгдэж үхсэн жуулчдын тоо баримтыг олон нийтэд мэдээлдэггүй. Зөвхөн тухайн ослыг үзсэн харсан хүмүүсийн дунд ам дамжин яригдахаас цаашгүй байгаа нь харамсалтай.
- Тайгын аялалд явдаг хөтөчдийн хувьд “Морины хөтөч нарын хандлага биеэ авч яваа байдал санаа зовоодог”. Мөн аялалын туршид хөтөч тогоочоо давхар хийж явдаг мөртлөө тогоочийн цалин огт бодогддоггүй. Өвөлдөө ядаж нэг удаа өөрийгөө хөгжүүлэх сургалтанд хамрагдмаар байдаг.
- Хотын аялалд явахад үйлчилгээний газрууд өглөө онгойдоггүй, дөнгөж онгойсон дэлгүүрүүдийн худалдагчдын ааш аяг гэж чөтгөр жигшмээр, аль болох худалдан авалт хийлгэчих гээд байхад л ярвайгаад утсаа бариад суучихдаг. Бас хятад жуулчидтай гадуур явахад нутгийн иргэд, ер нь л локал хүмүүсээс зохисгүй хандлага байнга ирдэг.
- Жуулчдыг дагуулж явсан газар болгонд Монгол хүмүүсийн хаясан "хог" угтан авдаг. "Танайх үнэхээр ариун дагшин байгалтай улс мөн юмуу?" гэх асуулт эхний 1-2 өдөрт найдвартай тавигдана. Ус ундааны сав, архины шил, пивоны лааз, тамхины иш, гялгар уут тор хаа сайгүй хөглөрнө. Ариун цэврийн асуудал маш хүнд байдаг.
- Замын түгжрэл
- Монгол ахуй, соёлын талаар үзүүлэх таниулах нөхцөл боломж бүрдүүлэх
- Хөтөч гэдэг нь мэргэшил учраас нэгдсэн мэдлэг мэдээлэл, тоо баримт, судалгаа хоорондоо зөрүүтэй байдал
- Жуулчны олж авсан мэдээлэл худал байх вий гэж санаа зовдог
- Улирлын онцлогтой ажил тул нийгмийн даатгалын шимтгэл тогтмол төлөгддөггүй. Банкны зээл авахад хүндрэлтэй байдаг
- Жуулчдын соёлын ялгаанаас
- Эмэгтэй хөтөч орчуулагчын талаас бэлгийн хүчирхийлэл асар их байдаг санагдсан миний зүгээс бол энэ асуудалд хариулт алга
- Монголд аялал жуулчлалын салбар улирлын чанартай байдгаас хамаарч зөвхөн аялал жуулчлалын салбарт ажиллах боломжгүй тул мэргэшсэн ажиллах хүчний нөөц муутай байдаг.
- Жуулчны үйлчилгээний машинд 1-р эгнээ болон дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй баймаар санагддаг.

- Гандан хийд дээр 3 бадарчин маягийн жуулчид дагуулсан 20 арай хүрээгүй орчим насны нэгэн гайд хүүгийн ярих нь: Монголын лам нар бол маш өрөвдөлтэй хүмүүс. Тэд хааяа цуглаад өдөржин сууж Төвөд шүлэг уншин суудаг. Зарим нь сургуульд сураагүй тул бичиг үсэг мэдэхгүй, мөн буддагаас гадна мангас шиг дүртэй амьтдыг шүтдэг бөгөөд хүмүүст засал хийж мөнгө олдог. Тэдний амьдрал ёстой уйтгартай - no girlfriend, no party... гэж ярьсан.
- Аюулгүй байдал болон эмнэлгийн анхан шатны тусламж
- Эрүүл мэнд, эрсдэлийн даатгалд компаний зүгээс заавал хамруулах шаардлагатай байна.
- Жуулчдын аюулгүй байдал
- Хөдөө орон нутагт Toilette, ОО-ийн асуудал маш хүнд
- Хөдөө, орон нутгийн Camp-ийн хүмүүс нь англи хэлтэй байх х
- Үйлчилгээний байгууллагуудын харилцааны соёл
- Музей болон гандан, сүм хийд, үзвэр үйлчилгээ жуулчдад үзүүлэх зүйл баялаг биш
- Такси үйлчилгээний соёл, харилцаа
- Автозамын чанар, тэмдэглэгээ
- Хөдөө явах замд нойлын асуудал хүндрэлтэй холын замд явахад хоолны газруудын ам чанар болон ариун цэврийн шаардлага хангалтгүй байдал асуудалтай

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Нэгдсэн гарын авлагатай болох.
- Аяллын аюулгүй байдлыг хангах тал дээр компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэх. Хөтөч тайлбарлагчдын хувьд цалин орлого, урамшууллаа нэмүүлэх, ажлын шаардлагатай төхөөрөмж, хувцас хэрэглэл, бүх төрлийн гарын авлага нэн шаардлагатай талаар респондентууд тулгамдсан асуудлууд мөн ажил олгогчтой хийх гэрээнд тусгуулах хүсэлтэй байна.
- Жолооч, үйлчилгээний ажилтнуудын харилцааны асуудал
- Бүх хариуцлагыг хөтчид үүрүүлдэг байдлыг арилгах.
- Жуулчины үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд өөрсдийн сайт дээрх олон жилийн өмнөх мэдээлэл, маршрутаа засдаг байх.
- Ажил олгогч тухайн аяллын бүхий л үйлчилгээг маш сайн зохион байгуулж зохицуулаагүйгээс үүдэн олон хоног хэрээр явж ирээд үүрээр хотод орж ирэхэд байрлах газрын захиалгыг баталгуужуулаагүй байсан тохиолдлууд байгаа нь ажил олгогчийн зүгээс анхаарах.
- Ихэнхи аяллын компаниуд хөтчийг аяллын талаарх мэдээллээр гүйцэд хангадаггүйгээс улбаалан жуулчны сэтгэл ханамж муу байхаас өгсүүлээд, эрүүл мэндийн асуудалд нь хүндрэл учруулах эрсдэлтэй.



- Хөтөч тайлбарлагч нарт чанартай сургалтыг анхан, дунд гэх мэтчилэн шатлалтай байдлаар стандарт түвшинд зохион байгуулах, 2-с дээш жил ажиллаж байгаа хөтөч нарт зориулаад илүү нарийн мэдээллүүдийг өгөх буюу ахисан түвшинд палеонтологи археологид чиглэсэн сургалтуудыг орох гэх мэт сургалтыг агуулгын хүрээнд хязгаар тогтоовол оновчтой болов уу. Мөн төрөлжсөн хөтөч бэлтгэх сургалтуудыг олшруулах.
- Хөтөч тайлбарлагч нар аяллын үеийн бэрхшээл, хөтөч нарын ажлын ачаалал, цалин хөлс, нийгмийн даатгал, ажлын дадлага туршлага, хөтөчийг ажилд авдаг шалгуур, шинэ хөтөч нартай харилцах харилцаа, баазын ажилтан ба хөтөчийн хоорондох харилцаа, ажлын уялдаа холбоо, жолооч нарын бэлтгэл муу байдал, тэдний зүгээс хөтөчид үзүүлдэг дарамт, жуулчны баазын тохижилт үйлчилгээтэй холбоотой гомдол санал зэрэг олон асуудлыг шийдвэрлэх.
- Хөтөч тайлбарлагч нарын ур чадварыг дээшлүүлэх, аялал жуулчлалын дээд сургуулийн хичээлийн хөтөлбөр программд тусгуулах.
- Хөтөч тайлбарлагчийн нийгмийн асуудлыг одоогийн нөхцөлд хэрхэн шийдвэрлэх талаар нэгдсэн бодлого гаргах.
- Хөтөч өөрийн үүрэгт ажлын хүрээнд хууль эрхзүйн мэдлэгтэй байх.

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Насны бүтэц.....	6
Зураг 2. Хүйсийн харьцаа .....	6
Зураг 3. Өрхийн ам бүлийн тооны бүлэглэлт.....	6
Зураг 4. Мэргэжил эзэмшсэн байдал.....	7
Зураг 5. Ажилласан жил .....	7
Зураг 6. Гадаад хэлний мэдлэг.....	7
Зураг 7. Хөтөч тайлбарлагчийн гэрчилгээтэй эсэх.....	9
Зураг 8. Хөтөч тайлбарлагчийн амжиргааны байдал .....	9
Зураг 9. Зээлтэй эсэх .....	9
Зураг 10. Зээлийн хэмжээ.....	9
Зураг 11. Зээлийн төрөл.....	10

Зураг 12. Танд мэдлэг, ур чадвар дээшлүүлэх шаардлага гардаг эсэх	Зураг 13. Сургалтын байгууллагууд хөтөч, тайлбарлагч нарт бүрэн дүүрэн сургалт өгч чаддаг уу? .....	11
Зураг 14. Сургалтанд суусны дараа ур чадварын үнэлгээг сургалтын байгууллагуудаас эргэж холбогдож байсан уу? .....		11
Зураг 15. та ажлын байрны мэдээллийг хаанаас авдаг вэ? .....		12
Зураг 16. Таны нийгмийн асуудлыг тухайлбал эрүүл мэндийн асуудал тулгарах, орон сууц, автомашин худалдан авах, сургалтын төлбөр төлөх зэрэгт гэрээтэй байгууллагаас дэмжлэг туслалцаа үзүүлж байсан уу? .....		12
Зураг 17. Таны нийгмийн даатгалын төлөлт хэрхэн төлөгддөг вэ? .....		13
Зураг 18. Та ажлын үр дүнгээр урамшуулал авдаг уу? .....		13
Зураг 19. Хэрвээ урамшуулал авч байсан бол хэрхэн үнэлж олгож байсан бэ? .....		13
Зураг 20. Таньд үндсэн харьяалалтай аяллын компанитай байдаг уу? .....		14
Зураг 21. Байхгүй бол хэдэн компанитай хамтардаг вэ? .....		14
Зураг 22. Цаашид аялал жуулчлалын ямар төрлөөр мэдлэг мэдээлэлтэй болохыг хүсч байна вэ? .....		20
Зураг 23. Сургалтын агуулга, чиглэл хөтөлбөрийг боловсруулахад хөтөч тайлбарлагч, ажил олгогч нараас саналыг нь хэрхэн авдаг вэ? .....		24
Зураг 24. Танай компани аялал жуулчлалын салбарт хэд дэх жилдээ үйл ажиллагаа эрхэлж байгаа вэ? .....		24
Зураг 25. Аль орны зах зээл дээр голчлон ажилладаг вэ? .....		24
Зураг 26. Аялалын ачаалалтай саруудад Ойролцоогоор явдаг хөтчийн тоо .....		25
Зураг 27. Хөтөч тайлбарлагч нарын хүний нөөцийг хаанаас бүрдүүлдэг вэ? .....		25
Зураг 28. Хөтөч тайлбарлагчийг шалгаруулахдаа юуг гол болгож авдаг вэ? .....		25
Зураг 29. Хөтөч, тайлбарлагчийн НДШ төлдөг үү? .....		26
Зураг 30. Хөтөч, тайлбарлагчийн дотоод сургалтын програмтай юу? .....		26
Зураг 31. Хөтөч тайлбарлагч нарын гарын авлагатай эсэх .....		26
Зураг 32. Анхны тусламжийн сургалтанд жил бүр хамруулдаг уу ? .....		26
Зураг 33. Улсаас Хөтөч тайлбарлагчийн зэрэглэл олгох шаардлагатай эсэх .....		26
Зураг 28. Хөтөч тайлбарлагчийг шалгаруулахдаа юуг гол болгож авдаг вэ? .....		27

